

Connecting to nature, culture
and your community

Family resources

Байгаль, соёл ба өөрсдийн хүрээлэлтэйгээ холбоотой байх

Гэр бүлд зориулсан материал

Сургуулийн Өмнөх Боловсролын бодлого (Early Years Learning Framework) нь цэцэрлэг болон бага насны хүүхдэд зориулсан бүх төрлийн үйлчилгээ явуулдаг байгууллагуудын мөрдөх үндэсний хэмжээний боловсролын бодлого юм. Хүүхдийг зорилгот таван чиглэлээр сургаснаар тухайн хүүхэд сурах хатуужил, өндөр чадвартай болоход нь энэхүү бодлогын зорилго юм.

Сургалтын 2-р үр дүн бол хүүхдүүд өөрсдийн хүрээлэл болон амьдарч буй дэлхийтэйгээ холбоотой байх тухай юм. Хүүхдүүд бусадтай хэрхэн холбогдож, хамтарч ажиллах тухай суралцан мөн тэдний үйлдэл ямар нөлөөтэйг ойлгож эхэлнэ. Хүүхдүүд ялгаатай байдал, онцлогийг үнэлэн, тэмдэглэж мөн хүрээлэн буй орчноо хайрлаж сурна.

Early Years Learning Framework-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах линкээр орж танилцана уу:
<https://www.acecqa.gov.au/nqf/national-law-regulations/approved-learning-frameworks>

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ цэцэрлэг эсвэл бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбогдоорой. Хэрвээ утсаар холбогдоход танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны хүссэн дугаар руу залган мөн тухайн шугамд орчуулагчийг таньтай холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Сургуульд суралцах

Сургуулийн Өмнөх Боловсрол

Холбоотой байж, хувь нэмрээ оруулах гэдэг нь:

Хүүхдүүд хүрээлэн буй орчноо хэрхэн хайрлаж, хамгаалах тухай мэддэг байна

Хүүхдүүд өөрсдийгөө хамааралтай нэг хэсэг нь гэдгээ ойлгож, өөрийн хувь нэмрээ оруулж чадна гэдгээ мэддэг байна

Хүүхдүүд бусдад шударга хандах нь ямар утгатайг мэддэг байна

Хүүхдүүд хүн бүр ялгаатай боловч хамтдаа зүтгэснээр дэлхийг сайнаар өөрчилж чадна гэдгийг ойлгосон байна

Сурагчид өөрсдийн соёлын тухай хуваалцаж мөн бусад соёлын талаар суралцана (Сэдэв: Газарзүй)

Сурагчид хүндэтгэлтэй, бусадтай хамтран ажиллаж, мөн бусдад шударга ханддаг болно (Сэдэв: Биеийн тамирын боловсрол)

Сурагчид бүтээлч чадвараа ашиглан өөрсдийн хүрээлэл болон соёлтойгоо холбоотой байх болно (Сэдэв: Бүтээлч урлаг)

Сурагчид ирээдүйтэй зөв сонголтуудыг ойлгож, шийдвэр гаргаж чаддаг болно (Бүх сэдвийн хүрээнд)